



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 01/21

Улаанбаатар

Г

Г

**Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрөх тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 02/21

Улаанбаатар

Г

Т

**2021 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг зөвшөөрөх тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг Хавсралтаар зөвшөөрч баталсугай.
2. Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хороонд үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 03/21

Улаанбаатар

Г

Т

**Ноогдол ашиг хуваарилахгүй тухай  
ТУЗ-ийн шийдвэрийг батлах тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны санхүүгийн жилийн үйл ажиллагаанаас ноогдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг зөвшөөрч баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 04/21

Улаанбаатар

Г

Т

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай**

Монгол Улсын компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.1, 77.2 дахь хэсэг, “Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн саналаар

**Ердийн гишүүнд:**

- Раднаагийн Бадрах
- Амарсайханы Даваажав
- Бадрахын Наранзаяа
- Бат-Очирын Аригуун
- Батжаргалын Баярцэнгэл
- Өлзийбүрэнгийн Алдарбаяр нарыг

**Хараат бус гишүүнд:**

- Ёндонгийн Амарбат
  - Дансрангийн Энхболд
  - Лувсанчүлтэмийн Тэмүүжин нар тус тус сонгогдсон тул ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг Хувь нийлүүлэгчдийн дараагийн хурал хүртэл зөвшөөрч баталсугай.
2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох журам зааврыг мөрдөж ажиллахыг улируулан сонгосон ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 05/21

Улаанбаатар

Г

Г

**Компанийн хэлбэрийг өөрчлөх төслийг хэрэгжүүлэх тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай төслийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг зөвшөөрч баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 06/21

Улаанбаатар

Г

Т

**Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг батлах тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн эзэмшлийн 166А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, 57,4 га талбай бүхий Дэлгэрхааны хайлуур жоншны талбайг “Васо флюорит” ХХК-д худалдаж, шилжүүлэх талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг зөвшөөрч баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 07/21

Улаанбаатар

Г

7

**Хөрөнгө шилжүүлэх тухай  
ТУЗ-ийн шийдвэрийг батлах тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн өмчлөлд бүртгэлтэй дараах хөрөнгийг “Ваёо Флюорит” ХХК-д худалдах, шилжүүлэх талаар гаргасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрч баталсугай.

Үүнд:

- a. Э-1814000100 тоот газрын гэрчилгээтэй 5331 /м.кв/ газар бүхий Ү-1814000616 гэрчилгээтэй 1768 м.кв талбайтай албан конторын барилгын талбайн 70% болох 1237 м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг, 3731.7 м.кв талбай бүхий газрын хамт
- b. Э-1814000101 тоот газрын гэрчилгээтэй 7933 м.кв газар Ү-1814000315 тоот үл хөдлөхийн гэрчилгээтэй 792 м.кв талбай бүхий төв агуулахын барилгыг газрын хамт,
- c. Э-1814000092 тоот газрын гэрчилгээтэй 12030 м.кв газрын 8421 м.кв талбайг, Ү-1814000314 тоот үл хөдлөхийн гэрчилгээтэй 1420 м.кв сувиллын барилгын хамт “Ваёо Флюорит ” ХХК-д шилжүүлсүгэй.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 08/21

Улаанбаатар

Г

Г

**Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний тухай  
ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрөх тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн тухай хуулийн 62.1.3-д зааснаар хувьцаанд хөрвөх зээлийн гэрээтэй холбоотой ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрч баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**





**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 09/21

Улаанбаатар

Г

Г

**Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай  
ТУЗ-ийн шийдвэрийг батлах тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн тухай хуулийн 76.1.16, 88.1-д заасны дагуу өр төлбөр барагдуулахтай холбоотой их хэмжээний хэлцэл хийх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг зөвшөөрч баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**А.ДАВААЖАВ**



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 10/21

Улаанбаатар

Г

Т

**Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай**

“Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн хуралаас баталсан 05/21 дугаартай тогтоолын аливаа төрийн байгууллагад болон бусад байгууллагад хандах хуулийн хугацаа дууссан тохиолдолд, Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулахгүйгээр Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын өмнөөс Төлөөлөн Удирдэх Зөвлөлд 05/21 дугаартай тогтоол, шийдвэрийг дахин гаргах, болон компанийн хэлбэр өөрчлөхтэй холбоотой бусад бүрэн эрхийг олгож байгааг зөвшөөрч баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**А.ДАВААЖАВ**